



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 178

Ховд

“Чанартай боловсрол” дэд хөтөлбөр
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Хүүхдүүдийг багаас нь өөртөө итгэлтэй, суралцах чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй иргэн болон хөгжихөд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн “Чанартай боловсрол” дэд хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдуулан “Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтээр сургалтын чанарын үнэлгээг зохион байгуулах журам”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Хөтөлбөр, журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.

4.Хөтөлбөр, журмын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн үр дүнг жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА

Г.ПУРЭВГАНДИ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны
172 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

“ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ” ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхий нийтийн “тогтвортой хөгжлийн зорилтууд”-ын 4 дэх зорилго, “алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт -1.3, 2.1, 2.5, монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3 дахь зорилт, аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.4 дэх зорилтын хэрэгжилтийг хангах, орон нутгийн мэргэжлийн болон иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн санал, санаачилгууд нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

2.1.Хүүхдийг өөртөө итгэлтэй, бие даан суралцах чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй, дэлхийн иргэн болон хөгжихөд нь дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2.Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.

2.2.1. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулиудын бүтэц, хэв шинжийг оновчтой болгож, үр дүнд чиглэсэн /сургуульд сууринсан/ хүүхэд төвтэй хөгжлийн менежментийг нэвтрүүлэх

2.2.2. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэн, сургалтын чанарыг сайжруулах

2.2.3. Хүүхдийн хүмүүжлийг дээдэлсэн, зан чанар, ёс суртахуунтай уялдсан сургалт, нөлөөллийн ажлыг цэцэрлэг, сургуульд өргөжүүлж сурч, хөгжих нийгэм сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэх

2.3.Хөтөлбөрийг боловсролын салбарын бүх шатны удирдлага, багш, ажиллагсад, эцэг, эх, асран хамгаалагч хүүхэд, сурагчдын хамтын оролцоонд тулгуурлан 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1.Хөтөлбөрийн “Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулиудын бүтэц, хэв шинжийг оновчтой болгож, үр дүнд чиглэсэн /сургуульд

суурилсан/ хүүхэд төвтэй хөгжлийн менежментийг нэвтрүүлнэ” зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.1.Орон нутгийн онцлог, хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан, сургуулиудыг бүсчлэн, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, олон улсын хөтөлбөрийн сургалттай, бага, дунд, ахлах, цогцолбор сургуулийн бүтэц хэв шинжтэй байхыг судлан тогтоож, тогтвортой мөрдүүлнэ.

3.1.2.Цэцэрлэг, сургуулиудад хүүхэд төвтэй /сургуульд суурилсан/ хөгжлийн менежментийн нэвтрүүлнэ.

3.1.3.Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжсэн олон нийтийн оролцоот сургууль, цэцэрлэгийг хөгжүүлж, сургууль бүхлээрээ ажиллах арга, хандлагыг үйл ажиллагаанд нь нэвтрүүлэх “Тогтвортой хөгжлийн боловсрол” орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

3.1.4.Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд “үр дүн, гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцоо”-г нэвтрүүлнэ.

3.1.5.Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд “Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2015” стандартыг хэрэгжүүлнэ.

3.2.Хөтөлбөрийн “Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэн, сургалтын чанарыг сайжруулна” зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.1.Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургалт, хөгжлийн үйл ажиллагааны чанарын үнэлгээний орон нутгийн тогтолцоог бүрдүүлж, сурлагын үнэлгээний бодит байдал болон сургалтын чанарыг сайжруулах журам боловсруулан хэрэгжүүлж тэргүүний багш, хамт олныг алдаршуулна.

3.2.2. Монгол хэл, бичгийн сургалтын чанарыг дээшлүүлэн, үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлж, төрийн албан хэргийг 2025 оноос хос бичгээр хөтлөх явуулах бэлтгэл ажлыг аймгийн хэмжээнд бүрэн хангах зорилгоор “Монгол хэл, бичиг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

3.2.3.Багш, оюутан, сурагчдыг дэмжих, урамшуулах, хөгжүүлэх замаар нийгмийн болон орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх “Чадварлаг багш, сурагч, оюутан” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.2.4.Хичээлүүдийн кабинет, лабораториудын хуртээмжийг нэмэгдүүлж, ахлах ангийн зарим хичээлүүдийг ХоИС, Хөгжил политехник коллежийн лаборатори, дадлагын газруудыг түшиглэн зохион байгуулах боломжийг өргөжүүлнэ.

3.2.5.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төвүүдийг байгуулан орон нутаг дахь мэргэжлийн сургуулиуд, мэргэжлийн холбоодын хамтын үйл ажиллагааг өргөжүүлнэ.

3.2.6.Аймгийн тэргүүний цэцэрлэг, сургуулийг шалгаруулж урамшуулдаг байх

3.3.Хүүхдийн хүмүүжлийг дээдэлсэн, зан чанар, ёс суртахуунтай уялдсан сургалт, нөлөөллийн ажлыг цэцэрлэг, сургуульд өргөжүүлж, хүүхэд бүр цэцэрлэг, сургуульд хамрагдаж сурч, хөгжих нийгэм сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлнэ.

3.3.1.Орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, хүүхдийн дунд зохион байгуулах сургалт, хөгжлийн үйл ажиллагааг хамтран төлөвлөж, үр дүнг хэлэлцэн, тайлagnадаг соёлыг бий болгоно.

3.3.2.Хичээлээс гадуурх сургалтын ажлыг хүүхдийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, хөтөлбөрийн зорилготой нийцуулэн зохион байгуулна

3.3.3.Сургуулиудыг мэргэжлийн сэтгэл зүйчээр хангаж, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг нэмэгдүүлнэ.

3.3.4.Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн нэгдсэн судалгааг гарган, сургалт, хөгжлийн үйлчилгээнд хамруулна.

3.3.5.Хүүхдэд эрүүл мэндийн зөв дадал, хандлагыг сургалт хөгжлийн бүх үйл ажиллагаагаар дамжуулан олгож, амны хөндийн эрүүл мэнд, хөдөлгөөн эрүүл мэнд аяныг тогтмолжуулна.

3.3.6.Боловсролын байгууллагын ажиллагсдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах сургалт, нөлөөллийн ажлыг өргөжүүлнэ.

3.3.7.Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгцээнд нийцуулэн сургууль, цэцэрлэгийн барилга, өргөтгөл, их засварын хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж, эрсдэлгүй, ээлтэй орчинд хүүхэд хөгжих боломжийг нэмэгдүүлнэ

3.3.8.Боловсролын цахим платформыг нэвтрүүлж, цахим сургалтыг өргөжүүлэн, боловсролын салбарын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулна.

Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө:

4.1.1.Дэлхийн хөгжлийн чиг хандлага, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдсан сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, хэв шинж бүрдэж тогтвортой мөрдөгднө.

4.1.2.Хүүхдүүд багаасаа дэлхий нийтийн ирээдүйн иргэний хэрэгцээт чадваруудыг /хатуу, зөөлөн/ орон нутагтаа эзэмших боломж нэмэгдэнэ.

4.1.2.Орон нутгийн байгууллага, иргэдийн хүүхдийн хөгжил, хүмүүжил, сургалтын чанарыг сайжруулахыг дэмжсэн бодлого, үйл ажиллагааны уялдаа, хамтын ажиллагаа сайжирна.

4.1.3.Сургалтын чанарын нэгдсэн судалгааны тогтолцоо бүрдэж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, цэцэрлэг, сургуулийн үнэлгээний бодит байдал нэмэгдэнэ.

4.1.4.Аймаг, сум, байгууллага, хамт олны хөгжлийн төлөө багаараа ажиллах хандлагад зөрөг өөрчлөлт буй болно.

4.1.5.Боловсролын байгууллага, багш нарын ажлын үр дүн, үнэлэмж дээшилнэ.

4.2. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлт | Хэмжи х нэгж | Суурь түвшин | | Зорилтот түвшин | | | |
|---|--|--|--|-----------------|-----------------|------|-----------------|------|--|--|
| | | | | | 2021 | 2022 | 2023 | 2024 | | |
| Зорилт 3.1. “Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулиудын бүтэц, хэв шинжийг оновчтой болгож, үр дунд чиглэсэн /сургуульд сууринсан/ хүүхэд төвтэй хөгжлийн менежментийг нэвтрүүлнэ” | | | | | | | | | | |
| 1 | 3.1.1. Цэцэрлэг, сургуулиуд орон нутгийн онцлог, хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан, сургуулиудыг бүсчлэн, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, олон улсын хөтөлбөрийн сургалттай, бага, дунд, ахлах, цогцолбор сургуулийн хэв шинжтэй байхыг судлан тогтоож тогтвортой мөрдүүлнэ | Хүүхэд багачууд багасаа өөрийн онцлог, сонирхол, ирээдүйн хөгжилд нийцсэн, ажил мэргэжлийн чиг баримжаатай суралцах боломж нэмэгдэнэ. | Төрөлжсөн, гүнзгийрүүлсэн сургалттай сургууль | тоо | 3 | 5 | 7 | 12 | | |
| 2 | 3.1.2. Цэцэрлэг, сургуулиудад хүүхэд төвтэй /сургуульд сууринсан/ хөгжлийн менежментийг нэвтрүүлнэ. | Хүүхэд төвтэй хөгжлийн менежментийн загвар боловсруулах арга зүйд нийт багш, сургууль, цэцэрлэгийн эцэг, эхийн зөвлөлийн гишүүд суралцсан байна. | Арга зүйг түгээсэн цэцэрлэг, сургууль | тоо | 24 | 60 | - | 60 | | |
| 3 | | | Арга зүйд суралцсан хүн | Тоо | 26 | 840 | - | 840 | | |
| 4. | | Менежментийн зорилтын хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаа өргөжиж, хэрэгжилтийн үнэлгээ ахисан байна. | Менежментийн загвар боловсруулж хэрэгжүүлсэн сургууль, цэцэрлэг | тоо | 14 | 25 | 58 | 58 | | |
| 5. | | | Сургуулийн зорилгын хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулсан судалгаат хичээл | тоо | 0 | 250 | 400 | 580 | | |

| 5 | | | Сайн түгээсэн туршлагаа цэцэрлэг, сургууль | тоо | - | 12 | 24 | 58 |
|---|---|---|---|------|-----|------|------|------|
| 6 | 3.1.3. Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжсэн олон нийтийн оролцоот сургууль, цэцэрлэгийг хөгжүүлж, сургууль бүхлээрээ ажиллах арга, хандлагыг цэцэрлэг сургуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх "Тогтвортой хөгжлийн боловсрол" орон нутгийн дэд хөтөлберийг хэрэгжүүлнэ | Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд буй болсон байна. | Дэд хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 30 | 50 | 75 | 100 |
| 7 | 3.1.4. Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд "Үр дүн, гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцоо"-г нэвтрүүлнэ. | Үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоо бүх цэцэрлэг сургуулийн үйл ажиллагаанд нэвтэрсэн байна | Үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоо бүх цэцэрлэг сургууль | тоо | 0 | 18 | 58 | |
| 8 | 3.1.5. Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд "Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2015" стандартыг хэрэгжүүлэх хандлага нэмэгдэнэ. | Цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш нарын Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2015" стандартыг хэрэгжүүлэх хандлага нэмэгдэнэ. | Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2015" стандартын мэдлэг, олгох сургалтад хамрагдсан багш, удирдах ажилтан | тоо | 120 | 1800 | 2500 | 2500 |
| 9 | MNS ISO 9001:2015" стандартыг хэрэгжүүлнэ. | Боловсролын байгууллагуудын үйл ажиллагааны чанар хүртээмж сайжирна. | "Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2015" стандартыг нэвтрүүлсэн боловсролын байгууллага | тоо | 0 | 6 | 15 | 40 |

3.2. "Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэн, сургалтын чанарыг сайжруулна"

| | | | | | | | | | |
|----|---|--|--|----------|---------------------|-------|--------|--------|--|
| | | | | | | | | | |
| 10 | 3.2.1. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургалт, хөгжлийн үйл ажиллагааны чанарын үнэлгээний орон нутгийн тогтолцоог бүрдүүлж, сурлагын үнэлгээний бодит байдал болон сургалтын чанарыг сайжруулах журам боловсруулан хэрэгжүүлж тэргүүний багш, хамт олныг алдаршуулна. | Орон нутгийн хэмжээд сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд чанарын судалгаа авах нэгдсэн хуваарь гарч мөрдөгддөг болсон байна. | Чанарын судалгааны нэгдсэн хуваариар судалгаанд хамрагдсан цэцэрлэг сургуулийн тоо, хүүхдийн хамралт | Тоо хувь | 0 0 | 68 98 | 68 100 | 68 100 | |
| 11 | | Үнэлгээний бодит чанар дээшилж, сургалтын чанар сайжирна | Сурлагын чанарын үнэлгээний дундаж | хувь | 40,1 /2019 оны дун/ | 45 | 50 | 60 | |
| 12 | 3.2.2. Монгол хэл, бичгийн сургалтын чанарыг дээшлүүлэн, үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлж, териин албан хэргийг 2025 оноос хос бичгээр хөтлөх явуулах бэлтгэл ажлыг аймгийн хэмжээнд бүрэн хангах зорилгоор "Монгол хэл, бичиг" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ | Төрийн албан хэргийг 2025 оноос хос бичгээр хөтлөх боломж бүрдсэн байна. | Дэд хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 30 | 60 | 80 | 100 | |
| 13 | 3.2.3. Багш, оюутан, сурагчдыг дэмжих, урамшуулах, хөгжүүлэх замаар нийгмийн болон орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чадварлаг боловсон хүчиний бэлтгэх "Чадварлаг багш, сурагч, оюутан" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Багш нарыг чадваржуулах, орон нутгийн боловсон хүчиний хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан бэлтгэдэг болно. | Дэд хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 30 | 60 | 80 | 100 | |
| 14 | 3.2.4. Хичээлүүдийн кабинет, лабораториудын хүртээмжийг нэмэгдүүлж, ахлах ангийн зарим хичээлүүдийг ХоИС, Хөгжил | Мэргэжлийн хичээлийг лаборатори, дадлагын танхимд зохион байгуулж, сурагчдын | Математик, хими, физик, технологийн хичээлийн кабинеттай сургууль | тоо | 8 | 13 | 18 | 25 | |

| | | | | | | | | |
|---|--|--|---|------|-----|-----|-----|-----|
| 15 | политехник коллежийн лаборатори, дадлагын газруудыг түшиглэн зохион байгуулах боломжийг өргөжүүлнэ. | бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ. | ХоИС, Хөгжил политехник коллежийн лаборатори, дадлагын газарт хамтран нэгдсэн хөтөлбөрөөр зохион байгуулсан нэгж хичээл | тоо | 0 | 54 | 108 | 158 |
| 16 | 3.2.5.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төвүүдийг байгуулан орон нутаг дахь мэргэжлийн сургуулиуд, мэргэжлийн холбоодын оролцоотой мэргэжил сурталчлах ажлыг өргөжүүлнэ. | Сурагчдын ирээдүйн мэргэжлийнхээ дагуу шаардлагатай хичээлээ сонгон судлах боломж нэмэгдэнэ | Сонгон судалсан хичээлээрээ дараагийн шатны сургуульд элссэн сурагчид | хувь | 53 | 65 | 78 | 80 |
| 17 | 3.2.6.Аймгийн тэргүүний цэцэрлэг, сургуулийг шалгаруулж урамшуулдаг байх. | Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирна | Журам батлагдсан байна. Аймгийн тэргүүний цэцэрлэг сургууль | тоо | | 1 | | |
| Зорилт 3.3 Хүүхдийн хүмүүжлийг дээдэлсэн, зан чанар, ёс суртахуунтай уялдсан сургалт, нелөөллийн ажлыг цэцэрлэг, сургуульд өргөжүүлж, хүүхэд бүр цэцэрлэг, сургуульд хамрагдаж сурч, хөгжих нийгэм сэтгэл зүйн таатай орчныг бурдуулна. | | | | | | | | |
| 18 | 3.3.1.Орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, хүүхдийн дунд зохион байгуулах сургалт, хөгжлийн үйл ажиллагааг хамтран төлөвлөж, үр дүнг хэлэлцэн, тайлагнадаг соёлыг буй болгоно. | Хүүхдийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд ажлаа жил, улирлаар хамтран төлөвлөж, үр дүнг хэлэлцэн, сайжруулдаг болсон байна. | Хамтрагч байгууллагуудын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилт Үр дүнг хэлэлцэн сайжруулалт хийсэн үйл ажиллагаа | хувь | 0 | 90 | 95 | 100 |
| 19 | | | | хувь | 0 | 60 | 75 | 100 |
| 20 | 3.3.2.Хичээлээс гадуурх сургалтын ажлыг хүүхдийн хөгжлийн эрэлт, хэрэгцээ, хөтөлбөрийн зорилготой нийцүүлэн зохион байгуулна | Хүүхдийн хүмүүжил төлөвшил ёс суртахууныг төлөвшүүлэх дугуйлан секцүүд тогтмол үйл ажиллагаа явуулдаг | Цэцэрлэг, сургууль дээр явагдаж байгаа дугуйлан секц Дугуйланд хамрагдсан сурагчдын хамралт | Тоо | 325 | 330 | 330 | 340 |
| 21 | | | | Хувь | 5 | 7 | 10 | 20 |

| | | | | | | | | |
|----|--|--|--|------|------|--------------|--------------|--------------|
| | | болсон байна | | | | | | |
| 22 | 3.3.3. Сургуулиудыг мэргэжлийн сэтгэл зүйчээр хангаж, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг нэмэгдүүлнэ. | Сурагчид мэргэжлийн сэтгэл зүйн үйлчилгээ авах боломж бүх сургуульд бүрдсэн байна. | Мэргэжлийн сэтгэл зүйчтэй сургууль Сэтгэл зүйн үйлчилгээ авах боломж бүх бүрдүүлсэн танхимтай сургууль | тоо | 20 | 25 | 25 | 25 |
| 23 | | | | тоо | 11 | 24 | 25 | 25 |
| 24 | 3.3.4. Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн нэгдсэн судалгааг гарган, сургалт, хөгжлийн үйлчилгээнд хамруулна. | Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамрагдалт сайжирна | Тусгай хэрэгцээт хүүхдийн оношилгоо хийж нэгдсэн бүртгэлийг жил бүр шинэчлэн гаргах Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн СӨБ-ын хамралт, ЕБС-д хамралт | Tooo | 1 | 1 | 1 | 1 |
| 25 | | | | хувь | 45.7 | Aхисан байна | Aхисан байна | Aхисан байна |
| 26 | 3.3.5. Хүүхдэд эрүүл мэндийн зөв дадал, хандлагыг сургалт хөгжлийн бүх үйл ажиллагаагаар дамжуулан олгож, амны хөндийн эрүүл мэнд, хөдөлгөөн эрүүл мэнд аяныг тогтмолжуулна. | Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн биеийн хөгжлийн үзүүлэлт сайжирна. | Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн бие бялдрын хөгжлийн үзүүлэлтийн дундаж Эрүүл шүйтэй хүүхдийн хувь | хувь | 92 | 95 | 98 | 100 |
| 27 | | | | хувь | 54 | 60 | 65 | 70 |
| 28 | 3.3.6. Боловсролын байгууллагын ажиллагсдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах сургалт, нелөөллийн ажлыг өргөжүүлнэ. | Боловсролын байгууллагын ажиллагсдын ёс зүй, харилцаа хандлага сайжирна. | Боловсролын байгууллагын ажиллагсдын ёс зүйтэй холбоотой иргэдийн гомдол, зөрчил | тоо | 8 | 0 | 0 | 0 |
| 29 | 3.3.7. Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгцээнд нийцүүлэн сургууль, цэцэрлэгийн барилга, өргөтгөл, | Цэцэрлэг сургуулийн орчны зарим стандартын хэрэгжилт сайжирч, эрсдэлгүй, | Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг | тоо | 1 | 1 | 1 | 1 |

| | | | | | | | | | | | |
|----|---|---|-------|--|---|-----------------------------------|-----|----|----|----|----|
| | их засварын оруулалтын төлөвлөлтийг хэрэнгэ нэгдсэн боловсруулан хэрэгжүүлж, эрсдэлгүй, эзлтэй орчинд хүүхэд хөгжих боломжийг нэмэгдүүлнэ. | хөгжлийн нэмэгдэнэ. | орчин | шинэчлэн боловсруулж мөрдсөн байна. | | | | | | | |
| 30 | | | | Хүүхдийн тоглоомын болон биесийн тамирын талбай, ариун цэврийн байгууламж, хоолны газрын стандартыг хэрэгжүүлнэ. | Стандартад тоглоомын биесийн талбайтай сургууль | нийцсэн талбай, тамирын цэцэрлэг, | тоо | 20 | 30 | 45 | 58 |
| 31 | | | | | Ариун цэврийн байгууламжийн нэгдсэн системд холбогдсон сургууль, дотуур байр, цэцэрлэг. | | тоо | 40 | 48 | 58 | 58 |
| 32 | | | | | Стандартад хоолны сургууль | нийцсэн газартай | тоо | 19 | 23 | 25 | 25 |
| 33 | 3.3.8.Боловсролын цахим платформыг нэвтрүүлж, цахим сургалтыг өргөжүүлэн, боловсролын салбарын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулна | Цахимаар суралцах боломж нэмэгдэнэ | | Хосолсон сургалтын танхимтай сургууль | | тоо | 1 | 21 | 25 | 25 | |
| 34 | | Багш, сурагч, эцэг эхчүүд боловсролын мэдээлэл авах боломж сайжирна | | Боловсролын цахим платформыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн сургууль, цэцэрлэг | | тоо | 0 | 25 | 58 | 58 | |

Тав."ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ" ДЭД ХӨТЕЛЬБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| | | | | | | | | | | |
|---|---|--|--|--------------------------------------|---|---|---|---|-----------------------|-----|
| | 3.1.1.Цэцэрлэг, сургуулиуд орон нутгийн онцлог, хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан, сургуулиудыг бүсчлэн, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, олон улсын хөтөлберийн сургалттай, бага, дунд, ахлах, цогцолбор сургуулийн хэв шинжтэй байхыг судлан тогтоож тогтвортой мөрдүүлнэ | Хүүхэд багачууд багасаа өөрийн онцлог, сонирхол, ирээдүйн хөгжилд нийцсэн, ажил мэргэжлийн чиг баримжаатай суралцах боломж нэмэгдэнэ. | Цэцэрлэг, сургуулийн хэв, шинж, бүтцийг орон нутгийн хөгжлийн эрэлт, онцлогт нийцүүлэн оновчтой тогтоох судалгаа хийж, шинэчлэн тогтоох, мөрдүүлэх | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, БГ | 0 |
| 2 | 3.1.2.Цэцэрлэг, сургуулиудад хүүхэд төвтэй /сургуульд суурилсан/ хөгжлийн менежментийн нэвтрүүлнэ. | Хүүхэд төвтэй хөгжлийн менежментийн загвар боловсруулах арга зүйд нийт багш, сургууль, цэцэрлэгийн эцэг, эхийн зөвлөлийн гишүүд суралцсан байна. | Хүүхэд төвтэй хөгжлийн менежментийн загвар боловсруулах арга зүйд нийт багш, сургууль, цэцэрлэгийн эцэг, эхийн зөвлөлийн гишүүд суралцсан байна. | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | | | БГ | 1.2 |
| 3 | | Менежментийн зорилтын хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаа өргөжиж, хэрэгжилтийн | Цэцэрлэг, сургуулийн зорилгын хэрэгжилтийг хангаж байгаа байдалд судалгаат хичээл зохион | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | БГ | 2 |

| | | | | | | | | | | |
|---|--|---|---|--------------------------------------|---|---|---|---|-----------------------------|-------------------------------|
| | | үнэлгээ ахисан байна | байгуулах, хичээлийн жилийн эцэст үнэлгээ хийн сайжруулан мөрдөх, тэрүүн туршлагыг түгээх | | | | | | | |
| 4 | 3.1.3. Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжсэн олон нийтийн оролцоот сургууль, цэцэрлэгийг хөгжүүлж, сургууль бүхлээрээз ажиллах арга, хандлагыг үйл ажиллагаанд нь нэвтрүүлэх "Тогтвортой хөгжлийн боловсрол" орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд бүхлээрээз ажиллах арга зүй нэвтэрсэн байна. | Дэд хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулах | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | БГ | Дэд хөтөлбөрийн санхүүжилтээр |
| 5 | 3.1.4. Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд "Үр дүн, гүйцэтгэлд сууринсан цалин хөлсний тогтолцоо"-г нэвтрүүлнэ. Үр дүнд сууринсан цалин хөлсний тогтолцоо бүх цэцэрлэг сургуулийн үйл ажиллагаанд нэвтэрсэн байна | Үр дүнд сууринсан цалин хөлсний тогтолцоо бүх цэцэрлэг сургуулийн үйл ажиллагаанд нэвтэрсэн байна | Цалин хөлсний шинэ тогтолцоог боловсролын салбарын ажиллагсадад сурталчлан, удирдлага, нягтлан бодогчдыг сурган хэрэгжүүлэх | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | БГ | 1,0 |
| 6 | 3.1.5. Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд "Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2015" | Цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш нарын Чанарын удирдлагын | Цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш наарт Чанарын удирдлагын | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, СХЗГ, БГ | 1,2 |

| | | | | | | | | | | | |
|---|-------------------------|---|--|--------------------------------------|---|---|---|---|-----------------------------|---|--|
| | стандартыг хэрэгжүүлнэ. | тогтолцоо MNS ISO 9001:2015" стандартыг хэрэгжүүлэх хандлага нэмэгдэнэ. | тогтолцоо MNS ISO 9001:2015" стандартын, сургалт зохион байгуулах | | | | | | | | |
| 7 | | Боловсролын байгууллагуудын үйл ажиллагааны чанар хүртээмж сайжирна. | Боловсролын байгууллагуудын үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2015" стандартыг хэрэгжүүлэх | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, СХЗГ, БГ | 0 | |

Зорилт 3.1-ийн төсвийн дүн 5,4 сая төг

3.2. "Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэн, сургалтын чанарыг сайжруулна"

| | | | | | | | | | | |
|---|---|--|---|--------------------------------------|---|---|---|-----------------------|-----------------------|-------|
| 8 | 3.2.1. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургалт, хөгжлийн үйл ажиллагааны чанарын үнэлгээний орон нутгийн тогтолцоог бүрдүүлж, сурлагын үнэлгээний бодит байдал болон сургалтын чанарыг сайжруулах журам боловсруулан хэрэгжүүлж тэргүүний багш, хамт олныг алдаршуулна. | Орон нутгийн хэмжээд сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд чанарын судалгаа авах нэгдсэн хуваарь гарч мөрдөгддөг болсон байна. | Орон нутгийн хэмжээд сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд чанарын судалгаа хийх журам боловсруулан мөрдүүлэх, тэргүүний багш сургууль, хамт олныг урамшуулах | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, БГ | 216,0 |
| 9 | Үнэлгээний бодит чанар дээшилж, сургалтын чанар сайжирна | Жил бүр чанарын үнэлгээний нэгдсэн хуваарь гаргаж, судалгаанд сургачдыг бүрэн хамруулан, | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, БГ | 0 | |

| | | | | | | | | | | | | |
|----|--|---|--|--------------------------------------|---|---|---|---|-----------------------|-------------------------------|--|--|
| | | | хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа хийж, зөвлөмж гарган хэрэгжүүлэх | | | | | | | | | |
| 10 | 3.2.2. Монгол хэл, бичгийн сургалтын чанарыг дээшлүүлэн, үндэсний ёв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлж, төрийн албан хэргийг 2025 онос хос бичгээр хөтлөх явуулах бэлтгэл ажлыг аймгийн хэмжээнд бүрэн хангах зорилгоор "Монгол хэл, бичиг" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ | Төрийн албан хэргийг 2025 оноос хос бичгээр хөтлөх боломж бүрдсэн байна. | Хөтөлбөрийн зорилт ажиллагаа үйл | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ БГ | Дэд хөтөлбөрийн санхүүжилтээр | | |
| 11 | 3.2.3. Багш, оюутан, сурагчдыг дэмжих, урамшуулах, хөгжүүлэх замаар нийгмийн болон орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чадварлаг боловсон хүчний бэлтгэх "Чадварлаг багш, сурагч, оюутан" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Багш нарыг чадваржуулах, орон нутгийн боловсон хүчнийг хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан бэлтгэдэг болно. | Хөтөлбөрийн зорилт ажиллагаа үйл | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, БГ | Дэд хөтөлбөрийн санхүүжилтээр | | |
| 12 | 3.2.4. Хичээлүүдийн кабинет, лабораториудын хүртээмжийг | Мэргэжлийн хичээлийг лаборатори, дадлагын танхимд | Сургуулиудын математик, хими, физик, технологийн хичээлийн | ЕБС-25, | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, БГ | Улсын төсөв | | |

| | | | | | | | | | | | | |
|----|---|--|--|--|-----------------------|---|---|---|---|---|----------------|--|
| | нэмэгдүүлж, ангийн хичээлүүдийг Хөгжил коллежийн дадлагын түшиглэн байгуулах өргөжүүлнэ. | ахлах зарим ХоИС, политехник лаборатори, газруудыг зохион боловчийг хэрэгжүүлнэ. | зохион байгуулж, сурагчдын бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх боловчийг нэмэгдүүлнэ. | кабинетын хүрэлцээг сайжруулах | | | | | | | | |
| 13 | | | | ХоИС, Хөгжил политехник коллежийн лаборатори, дадлагын газруудтай хамтран зохион байгуулах хөтөлбөрийн судалгаа гаргаж хэрэгжүүлэх, | ЕБ-ын сургуулиуд, | + | + | + | + | БГ, ХоИС, Хөгжил политех ник коллеж | 0 | |
| 14 | 3.2.5. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төвүүдийг байгуулан орон нутаг дахь мэргэжлийн сургуулиуд, мэргэжлийн холбоодын оролцоотой мэргэжил сурталчлах өргөжүүлнэ | Сурагчдын ирээдүйн мэргэжлийнхээ дагуу шаардлагатай хичээлээ сонгон судлах боломж нэмэгдэнэ | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төв байгуулан сурагчдад зөвлөгөө өгөх үйл ажиллагааг тогтолжуулах | ЕБ-ын сургууль-25, | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, БГ, ХХҮГ, ХоИС, Хөгжил политех ник коллеж | Улсын төсөв | | |
| 15 | | | | Сургуулиудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох багийн байгуулан мэргэжлийн сургууль, холбоотой мэргэжил сурталчлах аяныг жилд 2 удаа зохион байгуулах | ЕБ-ын сургууль-25, | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, БГ, ХХҮГ, ХоИС, Хөгжил политех ник коллеж | Улсын төсөв | |

| | | | | | | | | | | |
|----|---|--|--|----------------------|---|---|---|---|------------------|--|
| 16 | 3.2.6. Аймгийн тэргүүний цэцэрлэг, сургуулийг шалгаруулж урамшуулдаг байх | Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирна. | Аймгийн тэргүүний сургууль, цэцэрлэг шалгаруулах журам боловсруулж батлуулна. Жил бүр тэргүүний цэцэрлэг, сургуулийг шалгаруулна. | Цэцэрлэг, сургуулиуд | + | + | | | Аймгийн ЗДТГ, БГ | |
| | | | | Цэцэрлэг, сургуулиуд | | + | + | + | Аймгийн ЗДТГ, БГ | |

Зорилт 3.2-ийн төсвийн нийт дүн: 216,0 сая төг

Зорилт 3.3 Хүүхдийн хүмүүжлийг дээдэлсэн, зан чанар, ёс суртахуунтай уялдсан сургалт, нөлөөллийн ажлыг цэцэрлэг, сургуульд өргөжүүлж, хүүхэд бүр цэцэрлэг, сургуульд хамрагдаж сурч, хөгжих нийгэм сэтгэл зүйн таатай орчныг бурдуулнэ.

| | | | | | | | | | | |
|----|--|--|--|------------------------------|---|---|---|---|-----------------------|-----|
| 17 | 3.3.1. Орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, хүүхдийн дунд зохион байгуулах сургалт, хөгжлийн үйл ажиллагааг хамтран төлөвлөж, үр дүнг хэлэлцэн, тайллагнадаг соёлыг буй болгоно. | Хүүхдийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд ажлаа жил, улирлаар хамтран төлөвлөж, үр дүнг хэлэлцэн, сайжруулдаг болсон байна. | Хүүхдийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын удирдлага, ажилтнуудын нэгдсэн уулзалтыг хагас, бүтэн жилээр хийж хийх ажлын нэгдсэн төлөвлөлт гарган мөрдөж, үр дүнг хэлэлцэн. | ГБХЗХГ, ЦГ,ХХҮХ,БТ СГ, бусад | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, БГ | 0 |
| 18 | 3.3.2. Хичээлзээс гадуурх сургалтын ажлыг хүүхдийн хөгжлийн эрэлт, хэрэгцээ, хөтөлбөрийн зорилготой нийцүүлэн зохион байгуулна | Хүүхдийн хүмүүжил төлөвшил ёс суртахууныг төлөвшүүлэх дугуйлан секцүүд тогтмол үйл ажиллагаа | Хичээлзээс гадуурх сургалт үйл ажиллагааг төлөвлөх зохион байгуулах арга зүйн сургалт | ЕБ-ын сургууль-25, НТБТ-2 | * | | | | БГ, | 1,0 |
| 19 | | | Иргэний ёс зүйн боловсрол олгох сургалтын агуулгыг | ЕБ-ын сургууль-25, НТБТ-2 | * | * | * | * | БГ, | 0 |

| | | | | | | | | | | | |
|----|---|--|---|--|---|---|---|-----------------------|---------------------|-----|--|
| | | явуулдаг болсон байна | орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн баяжуулж хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 20 | 3.3.3. Сургуулиудыг мэргэжлийн сэтгэл зүйчээр хангаж, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг нэмэгдүүлнэ. | Сурагчид мэргэжлийн сэтгэл зүйн үйлчилгээ авах боломж бүх сургуульд бүрдсэн байна. | Сургуулиудыг мэргэжлийн сэтгэл зүйчээр хангаж, нэгдсэн сургалт, зөвлөгөөн зохион байгуулна. | ЕБ-ын сургууль-25, НТБТ-2 | * | | * | БГ, ГБХЗХГ | 2,0 | | |
| 21 | | | Сургуульд бүрт сэтгэл зөвлөгөө өгөх нээж төвийг ажиллуулна. | ЕБ-ын сургууль-25, НТБТ-2 | * | | * | Аймаг, сумын ЗДТГ, БГ | 0 | | |
| 22 | 3.3.4. Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн нэгдсэн судалгааг гарган, сургалт, хөгжлийн үйлчилгээнд хамруулна. | Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамрагдалт сайжирна | Тусгай хэрэгцээт хүүхдийн илрүүлэлтийг хийж, нэгдсэн бүртгэлийг жил бүр шинэчлэн гаргана | 17 сумын цэцэрлэг, сургуулийн насын хүүхдүүд | 0 | + | + | + | ЗДТГ, ЭМГ, ХХҮХ, БГ | 0 | |
| 23 | | | Багш нарын тэгш хамруулах мэдлэг, арга зүйг сайжруулах, эцэг эх олон нийтийн ойлголт, оролцоо, хандлагыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах | ЕБ-ын сургууль-25, НТБТ-2 | + | + | | + | БГ | 1.2 | |
| 24 | 3.3.5.Хүүхдэд мэндийн зөв дадал, сургалт хандлагыг | эрүүл Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн биеийн | Цэцэрлэг сургуулиудыг мэргэжлийн эмч, | Хүүхдийн цэцэрлэг -33 | + | + | + | + | Аймаг, сумын | 4,0 | |

| | | | | | | | | | | | |
|----|---|--|--|--------------------------------------|---|---|---|---|----------------------------|----------|--|
| | хөгжлийн бүх үйл ажиллагаагаар дамжуулан олгож, амны хөндийн эрүүл мэнд, хөдөлгөөн эрүүл мэнд аяныг тогтмолжуулна . | хөгжлийн үзүүлэлт сайжирна. | хоол зүйчээр хангаж, жил бүр чадваржуулах сургалтад хамруулна. | ЕБС-25, НТБТ-2 | | | | | | ЗДТГ, БГ | |
| 25 | | | "Үдийн хоол" хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт үнэлгээг тогтмолжуулна. | ЕБ-ын сургууль-25, НТБТ-2 | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, БГ | 0 | |
| 26 | | | Хөдөлгөөн эрүүл мэнд аяныг жил бүр зохион байгуулж "Эрүүл шүдтэй хүүхдүүд" анги бүлгийг шалгаруулан урамшуулна | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | - | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, ЭМГ, БГ | 10,0 | |
| 27 | | | Хөдөлгөөн эрүүл мэнд аяныг жил бүр зохион байгуулж "Эрүүл мэндийг дэмжигч" анги бүлгийг шалгаруулан урамшуулна | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | - | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, ЭМГ, БГ | 10,0 | |
| 28 | 3.3.6.Боловсролын байгууллагын ажиллагсдын ёс зүй, харилцаа хандлагыг сургалт, ажлыг | Боловсролын байгууллагын ажиллагсдын ёс зүй, харилцаа хандлага сайжирна. | Боловсролын байгууллагын ажиллагсдын ёс зүйн сургалт зохион байгуулна | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | - | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, ЭМГ, БГ | | |

| | | | | | | | | | | | | | |
|----|---|--|---|--------------------------------------|---|---|---|---|--|--|--|-----------------------|------------------|
| | | | | | | | | | | | | | |
| 29 | 3.3.7.Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгцээнд нийцүүлэн сургууль, цэцэрлэгийн барилга, өргөтгөл, их засварын хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж, эрсдэлгүй, ээлтэй орчинд хүүхэд хөгжих боломжийг нэмэгдүүлнэ. | Хүүхдийн тоглоомын болон биеийн тамирын талбай, ариун цэврийн байгууламжийн, стандартыг хэрэгжүүлнэ. | Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгцээнд нийцүүлэн сургууль, цэцэрлэгийн барилга, өргөтгөл, их засварын хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг боловсруулан тогтвортой мөрдүүлнэ. | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | | | | Аймаг, сумын ЗДТГ, БГ | 0 |
| 30 | | | Хүүхдийн тоглоомын болон биеийн тамирын талбайг стандартад нийцүүлэн тохижуулна | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | | | | Аймаг, сумын ЗДТГ, БГ | 100,0 |
| 31 | | | Цэцэрлэг, сургуулийн ариун цэврийн байгууламжийг нэгдсэн системд бүрэн холбоно. | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | | | | Аймаг, сумын ЗДТГ, БГ | Улсын төсөв |
| 32 | | | Сургуулиудын цайны газрын тоног төхөөрөмжийг шинэчилнэ., | ЕБ-ын сургууль-25, НТБТ-2 | + | + | + | + | | | | Аймаг, сумын ЗДТГ, БГ | Улсын төсөв, ОУБ |
| 33 | 3.3.8.Боловсролын цахим платформыг нэвтрүүлж, цахим | Цахимаар суралцах боломж нэмэгдэнэ | Сургуулиудад хосолсон сургалтын танхим байгуулна. | ЕБ-ын сургууль-25, НТБТ-2 | + | + | + | + | | | | Аймаг, сумын | 540,0 |

| | | | | | | | | | |
|----|---|---|--|--------------------------------------|---|---|---|----------|-----------------------|
| | сургалтыг өргөжүүлэн, боловсролын салбарын мэдээллийн ил тод, байдлыг | | | | | | | ЗДТГ, БГ | |
| 34 | | Багш, сурагч, эцэг эхчүүд боловсролын мэдээлэл авах боломж сайжирна | Боловсролын цахим платформыг нэвтрүүлнэ. | Хүүхдийн цэцэрлэг -33 ЕБС-25, НТБТ-2 | + | + | + | + | Аймаг, сумын ЗДТГ, БГ |

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

6.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт нь улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн дэмжлэг, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ТАЙЛАГНАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

7.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллагууд хийж хэрэгжүүлсэн ажил, хүрсэн үр дүнгийн тайланг журмын дагуу боловсруулж, хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст тайлагнана.

7.2.Хөтөлбөрийн тайланг жилийн эцсийн байдлаар нэгтгэн боловсруулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлнэ

7.3.Хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын болон шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийнэ.

7.4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажлыг нэгтгэн дүгнэж, Засаг даргын Зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлсний үндсэн дээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулна.

---000---

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны
178.дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭЭР ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ
СУДАЛГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Зорилго: Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургалт, хөгжлийн үйл ажиллагааны чанарын үнэлгээний тогтолцоог бүрдүүлж, сурлагын үнэлгээний бодит байдлыг сайжруулж, сургалтын чанарт ахиц гаргана.

Хамрах хүрээ: Ховд аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль

Нэг: Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн анги хамт олныг тодорхой судлагдахуунаар чанарын үнэлгээний судалгаанд жил бүр 1-2 удаа хамруулж, хичээл бүрийн улирлын үр дүнгийн үнэлгээг тухайн судалгааны дүнгээр тооцох үйл ажиллагааг мөрдүүлнэ.

Үнэлгээний даалгаврыг тухайн судлагдахууны сургалтын хөтөлбөрийн төлөвлөлттэй уялдуулан аман, бичгийн, тестийн хэлбэрээр боловсруулж, боловсролын газрын мэргэжилтний зөвлөлөөр баталгаажуулсан байна. Тухайн хичээлийн судалгааг аймгийн хэмжээнд ижил хугацаанд сум орон нутгийн удирдах байгууллага, эцэг эхийн төлөөллийн хөндлөнгийн хяналттайгаар авахаас гадна нэгдсэн зохион байгуулалттайгаар Боловсролын газраас томилсон хянагч багшаар авхуулж болно.

Тухайн жилд Боловсролын үнэлгээний төвөөс авсан чанарын үнэлгээний үндэсний судалгаатай давхцуулахгүй бөгөөд энэ судалгааны дүнг орон нутгийн чанарын судалгааны дүнд тооцно.

Чанарын үнэлгээний судалгааны дүнг өгсөн зааврын дагуу сургуулийн өмнөх боловсролын арга зүйч, сургуулийн сургалтын менежер, хянагч багш нар нэгтгэн боловсролын газрын мэргэжилтэнд тухайн өдөртөө багтаан цахимаар ирүүлнэ. Чанарын үнэлгээний судалгааг тухайн мэргэжилтэн нэгтгэн, даалгавар тус бүрийн гүйцэтгэлд шинжилгээ хийж, ажлын 3 хоногт багтаан мэргэжилтний зөвлөлд танилцуулж, сургууль багш нарт зөвлөмжийг 7 хоногийн дотор багтаан хүргүүлнэ.

Судалгааны шинжилгээ, зөвлөмжийг сургуулийн мэргэжлийн багш нар ЗАН, секцээр хэлэлцэн, хөтөлбөрийн төлөвлөлт, арга зүйг сайжруулах төлөвлөлт хийн, хэрэгжүүлж буй байдалд сургалтын менежер хяналт тавин ажиллана.

Чанарын үнэлгээний судалгааг хичээл ангиар, аймаг, сумын ИТХ, Засаг даргын болон бусад байгууллага, иргэдийн нэрэмжит болгон зохион байгуулж болно. Энэ тохиолдолд тухайн үнэлгээг зохион байгуулахад гарах үйл ажиллагааны зардал болон шагналыг тухайн байгууллага, иргэн хариуцна.

Хоёр: Орон нутгийн чанарын үнэлгээний судалгаанд хамрагдах анги, хичээлийг сонгон нийтэд мэдээлэх

Тухайн хичээлийн жилийн зорилго, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааны дүнг үндэслэн анги бүрээс авах чанарын судалгааны төрөл, хугацааг боловсролын газрын мэргэжилтний зөвлөлийн хурлаар жил бүрийн 8 дугаар сарын сүүлийн хагаст хэлэлцэн шийдвэрлэж, нийтэд мэдээлнэ.

Сургуулиудад: Чанарын үнэлгээний судалгаа авах хуваарь
/Хичээлийн жилийн эхэнд хугацаа, төрлийг тогтоох/

| | | | | | | | | | | | | |
|----|------------------------------------|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| 18 | Дүрслэх урлаг, дизайн технологи | | | | | | | | | | | |
|----|------------------------------------|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|

**Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн хөгжлийн үнэлгээ
хийх үзүүлэлт**

| № | Хөгжлийн үзүүлэлт | Дунд бүлэг | Ахлах бүлэг | Бэлтгэл бүлэг |
|---|-------------------|------------|-------------|---------------|
| 1 | Бие бялдар | | | |
| 2 | Танин мэдэхүй | | | |
| 3 | Нийгэмшихүй | | | |

Гурав: Чанарын үнэлгээний судалгаагаар аймагтаа тэргүүлсэн анги хамт олон, багшийг судалгаа хийсэн анги, судлагдахуун бүрээр дараах байдлаар шалгаруулан шагнаж, урамшуулна. Үүнд:

| № | Байр | Аймгийн төвийн Сургуулийн өмнөх боловсрол, сургуулиуд | | Хөдөөгийн сумдын Сургуулийн өмнөх боловсрол, сургуулиуд | |
|---|--------------|---|--------------------------|---|-----------------------|
| | | Анги хамт олон | Хичээл заасан багш | Анги хамт олон | Хичээл заасан багш |
| 1 | Тэргүүн байр | 300000 | 500000 | 300000 | 500000 |
| 2 | Дэд байр | 250000 | 400000 | 250000 | 400000 |
| 3 | Гутгаа байр | 200000 | 300000 | 200000 | 300000 |
| | Дүн | 750000 | 1200000 | 750000 | 1200000 |

Тухайн хичээлийн жилийн чанарын үнэлгээний судалгааны нэгдсэн дүнгээр заадаг хичээлийн гүйцэтгэл нь сум болон сургууль, цэцэрлэгийн хэмжээнд эхний 3 байр эзэлсэн багш нарыг сумын Засаг дарга, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын нэрэмжит шагналаар шагнаж урамшуулна. Шагналыг давхардуулан олгохгүй.

Тухайн жилд хийгдсэн нийт чанарын үнэлгээний судалгааны гүйцэтгэлүүдийн дунджаар сургуулийн өмнөх боловсрол, сургуулиудыг дараах байдлаар шалгаруулж, шагнаж урамшуулна.

Тэргүүний үнэлгээтэй сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургуулиуд:

| № | Байр | Аймгийн төвийн | Хөдөөгийн сумдын |
|---|------|----------------|------------------|
|---|------|----------------|------------------|

| | | Сургуулийн өмнөх боловсрол, сургуулиуд | Сургуулийн өмнөх боловсрол, сургуулиуд |
|---|--------------|---|---|
| 1 | Тэргүүн байр | 10000000 хүртэл төгрөг | 10000000 хүртэл төгрөг |
| 2 | Дэд байр | 8000000 хүртэл төгрөг | 8000000 хүртэл төгрөг |
| 3 | Гутгаар байр | 6000000 хүртэл төгрөг | 6000000 хүртэл төгрөг |
| | Дүн | 24000000 хүртэл | 24000000 хүртэл |

Чанарын үнэлгээний судалгаагаар заадаг хичээлийн дундаж нь хамгийн бага үнэлгээтэй шалгагдсан багшид тухайн байгууллагын дотоод журамд заасны дагуу сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдлага хариуцлага хүлээлгэнэ.

Чанарын үнэлгээний судалгаагаар заадаг хичээлийн дундаж нь 2 жил дараалан 40%-аас доош үнэлгээтэй дүгнэгдсэн багшийг өөрийн зардлаар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах боломжийг олгоно.

Чанарын үнэлгээний судалгаагаар заадаг хичээлийн гүйцэтгэл нь 2 удаа хамгийн доод үнэлгээтэй дүгнэгдсэн багшийг боловсролын тухай хуульд заасан багшийн эрх, үүргийг хэрэгжүүлээгүйд тооцож багшлах эрхийг цуцална.

Чанарын үнэлгээний судалгааны даалгаврын гүйцэтгэлийн нэгдсэн шинжилгээг сургууль, анги бүлгээр боловсролын цахим сайтад байршуулан багш нар сургалт хөгжлийн ажилдаа ашиглах боломж бүрдүүлэхийг Боловсролын газар хариуцан зохион байгуулна.

...ооо...